



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨН”-д ОЛГОСОН ЗЭЭЛ, ЭРГЭН ТӨЛӨЛТ, ҮР ДҮН ХИЙСЭН
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: БХА-2026/21-03/ШТА-ГА

“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд олгосон зээл нь малчдад эерэг нөлөө үзүүлж байгаа ч зорилтод тусгасны дагуу үйл ажиллагаа хорших хэлбэрээр бүрэн төлөвшөөгүй байна.”

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт

мэдээллийг дараах хаягаар авна уу
Цахим хуудас: www.open.audit.mn

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор **Б.Мөнхбат**

Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер **М.Алтантуяа**

Утас: 70442424 цахим хуудас: Altantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор **Б.Азбаяр**

Утас: 99061429 цахим хуудас: azbayarb@audit.gov.mn

Аудитор **А.Адилзаяа**

Утас: 80870886 цахим хуудас: Adilzayaa@audit.gov.mn

Аудитор **Д.Цэдэвцэвээн**

Утас: 89204984 цахим хуудас: Tsedevtseveend@audit.gov.mn

Аудитор **Н.Батчимэг**

Утас: 91113253 цахим хуудас: Batchimegn@audit.gov.mn

Баянхонгор хот 2026 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.open.audit.mn

Тайланг хянасан

Баянхонгор аймаг дахь
Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор
Б.Мөнхбат Аудитын
менежер М.Алтантуяа

Тайланг бэлтгэсэн:

Ахлах аудитор Б.Азбаяр
Аудитор А.Адилзаяа
Аудитор Д.Цэдэвцэвээн
Аудитор Н.Батчимэг

2026 оны 06 дугаар сарын 25-
ны өдөр

Уг тайланг УАГ-ын
цахим хуудаснаас үзнэ үү:
www.audit.mn

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах зүйл
байвал 70442424 дугаарын
утас, 70442584 дугаарын
факсаар харилцана уу.

ХАЯГ:

Баянхонгор аймаг дахь
Төрийн аудитын газар,
Нутгийн удирдлагын ордон,
Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум 64090,
Баянхонгор аймаг
Монгол Улс

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....3

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ.....4

БҮЛЭГ 1. ТӨРӨӨС ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨН ӨРНҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ТОДОРХОЙЛСОН ХӨТӨЛБӨР ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖИЖ БАЙНА УУ?

“ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨН ӨРНҮҮЛЭХ ТУХАЙ” АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОДОРХОЙЛООГҮЙ, САНХҮҮЖИЛТИЙГ БҮРЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.6

1.1.“Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай” арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг тодорхойлоогүй, санхүүжилтийг бүрэн төлөвлөөгүй байна.

БҮЛЭГ 2. ХОРШООГ ХУУЛЬД ЗААСАН ШААРДЛАГЫН ДАГУУ БАЙГУУЛЖ, ОЛГОСОН ЗЭЛИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ АШИГЛАЖ, ҮР ДҮНГ ТООЦОЖ БАЙНА УУ?..... 9

“ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨН”-ИЙ ХҮРЭЭНД ЗЭЭЛ АВСАН ЗАРИМ ЗЭЭЛДЭГЧИД ЗЭЭЛИЙН ХӨРӨНГИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН ЭСЭХ НЬ НОТЛОГДОХГҮЙ, ТӨСӨЛД ЗААСАН ҮЙЛ АЖЛЛАГАА ЖИГДРЭЭГҮЙ БАЙНА.9

2.1. Хоршоо шинээр үүсгэн байгуулахдаа хуульд заасан шаардлагын дагуу бүртгүүлж байгаа хэдий ч дийлэнх хоршооны тайлангаас үзэхэд үйл ажиллагаа явуулаагүй төлөвөөр санхүүгийн тайланг илгээсэн байна.....9

2.2. Хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр нь малчдын амьдралд чухал хувь нэмэр болсон хэдий байгаль уур амьсгалын нөхцөл байдал, хэрэгжих хугацаанаас шалтгаалж зээлийн үр ашгийг тодорхойлох боломжгүй байна.....13

ДҮГНЭЛТ:.....19

ЗӨВЛӨМЖ:20

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:.....21

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
УАГ	Үндэсний аудитын газар
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Шинэ хоршоо хөдөлгөөний төлөвлөгөөний хэрэгжилт	6
Хүснэгт 2	Баянхонгор аймгийн хэмжээнд олгосон зээлийн эргэн төлөлтийн дүн банкаар	13
Хүснэгт 3	Баянхонгор аймгийн хэмжээнд олгосон зээлийн эргэн төлөлтийн дүн банкаар	15
Хүснэгт 4	Зээлийн зориулалт	16

Зураглалын жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураглал 1	Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд олгосон зээлийн дүн	4
Зураглал 2	Зээлийн мэдээлэл /сумдаар/	5

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны 25 дугаар “Аудитын сэдэв батлах тухай” тогтоолоор баталсан Төрийн аудитын байгууллагын 2026 оны гүйцэтгэх аудитын сэдэв, МУЕА-ын 2026 оны А/174 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө”, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2026 оны А/01 дүгээр тушаалыг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.
Аудитын зорилт	Засгийн газрын 2024 оны 166 дугаар “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай тогтоолын хүрээнд Баянхонгор аймгийн малчдад олгосон зээл, эргэн төлөлт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, аудитын дүнг ҮАГ, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэв. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд: • Төрөөс Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх чиглэлээр тодорхойлсон хөтөлбөр үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх; • Хоршоог хуульд заасан шаардлагын дагуу байгуулж, олгосон зээлийг зориулалтын дагуу ашиглаж, үр дүнг тооцож байгаа эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Засгийн Газрын 2024 оны 166 дугаар “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай тогтоолоор “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөг баталсан. Тус төлөвлөгөөг хэрэгжүүлэгч байгууллагууд Аймгийн ЗДТГ, Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс, аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Монгол банкны Баянхонгор аймаг дахь салбар, Хаан банк болон Төрийн банк тэдгээрийн салбар, сумдын Засаг дарга нар болон Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 2024-2025 онд зээл авсан 396 хоршоо, 2,185 зээлдэгч хамрагдлаа.
Аудитын хязгаарлалт	Байхгүй.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 300, 400, 3000-3001, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-2020 “Төрийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ыг ашиглан холбогдох байгууллагаас ирүүлсэн судалгаа, мэдээлэл, эрх бүхий байгууллагын хяналтын тайлан, цахим болон цаасан суурьтай нотлох баримтад тодруулга авах, судалгаа, мэдээллийг нягтлан шалгаж, нэгтгэх, харьцуулах, тооцоолох, нэгтгэн, дүн шинжилгээ хийж, аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер М.Алтантуяа хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Азбаяр, аудитор А.Адилзаяа, Н.Цэдэвцэвээн, Н.Батчимэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв. Аудитын төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн дотор батлуулж, аудитын нээлтийг хийж, талбарын ажлыг 2026 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс 2026 оны 06 дугаар 12-ны өдрийг хүртэл гүйцэтгэж, тайлагналын үе шатны ажлыг 06 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн тайлангийн төслийг шалгагдагч байгууллагуудад 06 дугаар сарын 25-ний дотор хүргүүлэн, байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, гүйцэтгэлийн аудитын тайланг 2026 оны 06 дугаар 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар, Аймгийн Засаг дарга,

Хүндрэл бэрхшээл

болон холбогдох бусад байгууллагуудад хүргүүлэв.

Баянхонгор аймгийн нийт нутгаар гандуу зуншлага муу байгаагаас малчид бусад аймаг, сумдад отор, нүүдэл хийж байгаа нь зээлийн зориулалтыг газар дээр нь үзэхэд хүндрэлтэй байлаа.


ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Засгийн газрын 2024 оны 166 дугаар “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай тогтоолоор “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан мал аж ахуйн салбарт үүсэж болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл, малчдын хоршоог дэмжих замаар тогтвортой хөгжүүлэх зорилгоор “Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэхээр” 5 их наядын “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөг баталж, 2 чиглэлийн хүрээнд 13 арга хэмжээг тусгасан байна.

“Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний хүрээнд хөнгөлөлттэй зээлд хамрагдсан малчдыг орон нутгаар хүснэгтээр харуулбал:

Зураглал № 1. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд олгосон зээлийн дүн

тэрбум.төгрөг




Эх сурвалж: Монгол банкны зээлийн мэдээллийн сан

Дээрх арга хэмжээний хүрээнд хоршооны гишүүн малчинд хөрөнгө оруулалтын болон эргэлтийн хөрөнгийн зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгох арга хэмжээг зарим арилжааны банкуудтай хамтран зохион байгуулж, 2024, 2025 онд улсын

хэмжээнд нийт 894.8 тэрбум төгрөгийн зээл олгосноос Баянхонгор аймагт 64,3 тэрбум төгрөгийг 389 хоршооны 2185 зээлдэгч нарт олгосон байна.

Зураглал № 2. Зээлийн мэдээлэл /сумдаар/

сая.төгрөг



Эх сурвалж: Аудитын судалгааны үр дүн

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН

БҮЛЭГ 1. ТӨРӨӨС ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨН ӨРНҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ТОДОРХОЙЛСОН ХӨТӨЛБӨР ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖИЖ БАЙНА УУ?

“ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨН ӨРНҮҮЛЭХ ТУХАЙ” АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОДОРХОЙЛООГҮЙ, САНХҮҮЖИЛТИЙГ БҮРЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.

1.1. “Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай” тогтоолд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, санхүүжилтийг бүрэн тусган төлөвлөж, хэрэгжүүлж байна уу?

1.1. “Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай” арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг тодорхойлоогүй, санхүүжилтийг бүрэн төлөвлөөгүй байна.

1.1.2 “Шинэ хоршоо-чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөө-нд тухайн хэрэгжүүлэх арга хэмжээний хүрэх түвшин, шаардагдах хөрөнгийг бодитой тооцсон уу?

Орон нутгийн түвшинд “Шинэ хоршоо- чинээлэг малчин” арга хэмжээний хүрэх түвшнийг бодитой тооцоогүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай 166 дугаар тогтоолын хавсралтаар “Шинэ хоршоо-чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөг 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан.

“Баянхонгор аймгийн Засаг даргын 2024-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.6.7-д “Шинэ хоршоо хөдөлгөөн, “Чинээлэг малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ”, мөн “Баянхонгор аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 8.1.2.3-д “Бүс орон нутгийн онцлогт нийцсэн үйлдвэрлэлийн кластер бий болгох замаар “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд хоршоодын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ” гэж тусгасан байна.

Харин Аймгийн 2024, 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд Баянхонгор аймгийн хэмжээнд “Шинэ хоршоо- чинээлэг малчин” арга хэмжээний хүрэх түвшин, шаардагдах хөрөнгийг ерөнхий байдлаар буюу тодорхой нэршлээр тус арга хэмжээг тусгаагүйгээс Шинэ хоршоо чинээлэг малчин төлөвлөгөөний хэрэгжилтийг улсын хүрэх түвшинтэй уялдуулан тайлагнаагүй байна.

“Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай 166 дугаар тогтоолын төлөвлөгөөний хэрэгжилтийг Баянхонгор аймгийн Засаг дарга болон аймгийн ХХААГ дараах байдлаар тайлагнасан байна.

Хүснэгт №1 Шинэ хоршоо хөдөлгөөний төлөвлөгөөний хэрэгжилт

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Шаардагдах хөрөнгө	Хэрэгжилт
1	Хоршооны гишүүн малчинд хөрөнгө оруулалтын зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгох	Малчдад олгосон зээлийн дүн	-	Банкны эх үүсвэр	64,288.0 сая төгрөг
2	Хоршооны гишүүн малчинд олгосон хөнгөлөлттэй	Хүүгийн зөрүүд олгосон дүн	-	Төсвийн зохицуулалтын эх	-

“Шинэ хоршоо хөдөлгөөн”-д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн

	зээлийн хүүгийн зөрүүг төрөөс хариуцах			үүсвэрээр	
3	Малжуулах хөтөлбөрт хамруулах	Малжуулах өрхийн тоо	2,750 малчин өрх	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	-
4	Зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, нөөц санг бүрдүүлэх	ЗБДС-ийн өөрийн хөрөнгийн хэмжээ	100,000.0	Төсвийн зохицуулалтын эх үүсвэрээр	-
5	“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг эхлүүлэх төв, орон нутгийн нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах	Хамрагдах хүний тоо	15,500	Төсвийн зохицуулалтын эх үүсвэрээр	4,124 хүн
6	“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий бүсийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	Хамрагдах хүний тоо	7,500	Төсвийн зохицуулалтын эх үүсвэрээр	100 хүн
7	Орон нутагт ажиллах малчдад зөвлөн туслах үүрэг бүхий сургагч багш нарыг бэлтгэх сургалт зохион байгуулах	Сургалтад хамрагдах хүний тоо	660	Төсвийн зохицуулалтын эх үүсвэрээр	Улсын хэмжээнд 660 сургагч багш бэлтгэгдснээс Баянхонгор аймагт 40 сургагч багш
8	Бэлтгэгдсэн сургагч багш нарыг орон нутагт ажиллуулж, малчдыг идэвхжүүлэх	Ажилласан хугацаа, хүний тоо, мэдээлэл авсан малчин өрхийн тоо	1,320	Төсвийн зохицуулалтын эх үүсвэрээр	12,951 хүн мэдээлэлд хамрагдсан
9	Мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодыг чадавхжуулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, энэ хүрээнд мэдээллийн нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх	Үйлчилгээ авсан малчин, иргэн, өрхийн тоо	1,600 хоршоо	Төсөл, хөтөлбөр	350 малчин
10	Мал аж ахуйн чиглэлийн хоршооны загвар төслүүдийг бэлтгэх	Бэлтгэсэн загвар төслийн тоо	50	Төсвийн зохицуулалтын эх үүсвэрээр	-
11	Малчдад зориулсан цахим системийг хөгжүүлж, шаардагдах мэдээллийг байршуулах	Мэдээлэл авсан малчин, иргэдийн тоо	298,000 малчин	Төсвийн зохицуулалтын эх үүсвэрээр	86 хоршоо
12	2024 оны хагас жилийн мал тооллогыг зохион байгуулах	Мал, малчин өрхийн тоо	-	Төсвийн зохицуулалтын эх үүсвэрээр	889,433 толгой мал тоологдсон
13	Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд газар олгох асуудлыг зохион байгуулах	Газар олгосон малчдын хоршоочдын тоо	-	-	2 сумд 8 газар эзэмшүүлсэн

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг дарга, ХХААГ-ын төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан

“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ний хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд орон нутгаас хөрөнгө төлөвлөж зарцуулаагүй, Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/280 дугаар захирамжаар “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг төрөөс баримтлах бодлого, чиглэлийг орон нутагт чанартай зохион байгуулж, нэгдсэн арга зүйгээр хангаж ажиллах ажлын хэсгийг 9 хүний бүрэлдэхүүнтэй томилогдсон ажлын хэсэг зохион байгуулалтын үйл ажиллагаанд оролцож ажилласан байна.

Аудитын илрүүлэлт:

Баянхонгор аймгийн хэмжээнд “Шинэ хоршоо- чинээлэг малчин” арга хэмжээний хүрэх түвшин, шаардагдах хөрөнгийг тооцоогүй, тодорхой нэршлээр тусгаагүйгээс төлөвлөгөөний хэрэгжилтийг улсын хүрэх түвшинтэй уялдуулан тайлагнаагүй байна.

Иймд “Шинэ хоршоо- чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж, хүрэх түвшиндээ хүрсэн эсэх талаар үр дүнд чиглэсэн тайланг бэлтгэн ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

1.1.3 “Шинэ хоршоо-чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий байгууллага нь чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаж байна уу?,

“Шинэ хоршоо-чинээлэг малчин” арга хэмжээний хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажилласан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай 166 дугаар тогтоолын 4 дэх хэсэгт “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлж, оролцогчдыг уялдаа, зохион байгуулалтаар хангаж ажиллах чиг үүргийг Жижиг дунд үйлдвэрийн газарт хариуцуулсан байна.

Тус төлөвлөгөөний 7 дахь хэсэгт Малчдын хоршооны хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааг орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулах чиглэлээр аймгийн Засаг дарга нарт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайдад даалгасан байна.

“Шинэ хоршоо-чинээлэг малчин” арга хэмжээг хэрэгжүүлэх арга зүй, чиглэлийг ЗГХЭГ-аас өгч ажилласан ба дээрх байгууллагуудын тогтоолоор өгсөн үүргийг орон нутагт аймгийн Засаг дарга, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар хэрэгжилтийг хариуцаж ажилласан байна.

“Шинэ хоршоо-чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөг 13 арга хэмжээнээс 6 төсөл арга, хэмжээнд аймгийн ЗДТГ болон аймгийн ХХААГ хамтран хэрэгжүүлэхээр тусгасан ба хэрэгжилтийг 2024-2026 оны байдлаар нэг удаа ЗГХЭГ-т тайлагнажээ.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны А/280 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг тус ажлын хүрээнд Баянхонгор аймгийн хэмжээнд дараах арга хэмжээ зохион байгуулсан байна. Үүнд:

- “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг эхлүүлэх төв, орон нутгийн нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд 20 сумын хэмжээнд малчин өрхүүдэд сурталчлан таниулж, мэдээлэл,

зөвлөгөө өгснөөр Баянхонгор аймгийн 4,124 малчин хоршоонд нэгдэж үйл ажиллагаа явуулж байна.

- “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий бүсийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хүрээнд Архангай аймагт 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулагдсан уулзалт хэлэлцүүлэгт 100 гаруй төлөөлөл оролцож, аймгийн 5 хоршоо үйл ажиллагаа танилцуулсан.
- Орон нутагт ажиллах малчдад зөвлөн туслах үүрэг бүхий сургагч багш нарыг бэлтгэх сургалт зохион байгуулах ажилд ЗГХЭГ-аас томилогдсон 40 сургагч багш, сумдын хөдөө аж ахуйн мэргэжилтнүүд нийт 66 хүний бүрэлдэхүүнтэй 20 ажлын хэсэг малчдад “Шинэ хоршоо-чинээлэг малчин” хөдөлгөөний танилцуулга, хоршоо байгуулах, төрөөс олгогдох хөнгөлөлттэй зээл олголтын талаарх мэдээллийг хүргэж ажилласан.
- Бэлтгэгдсэн сургагч багш нарыг орон нутагт ажиллуулж, малчдыг идэвхжүүлэх ажлын хүрээнд Баянхонгор аймагт хуваарилагдсан 40 сургагч багш орон нутагт ажиллаж 20 сумын 12,951 малчинд мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан.
- 2024 оны хагас жилийн мал тооллогыг зохион байгуулах ажил нь Үндэсний статистикийн хорооны чиглэлийн дагуу түүвэрт сонгогдсон 20 сумын 3,073 нэгжид тооллого хийж 889,433 толгой мал тоологдсон байна.
- Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд газар олгох асуудлыг зохион байгуулах ажлын хүрээнд 2025 онд мал аж ахуйн үйлдвэрлэл, тэжээлийн ургамал тариалах зориулалтаар 6 суманд 71 га газрын тусгаж Засгийн газраар батлуулсан ба 2 сумын 8 газарт төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулж газар эзэмшүүлсэн байна.

“Шинэ хоршоо-чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, тайланг аймгийн ХХААГ 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр тайлагнаж ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.

БҮЛЭГ 2. ХОРШООГ ХУУЛЬД ЗААСАН ШААРДЛАГЫН ДАГУУ БАЙГУУЛЖ, ОЛГОСОН ЗЭЭЛИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ АШИГЛАЖ, ҮР ДҮНГ ТООЦОЖ БАЙНА УУ?

“ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨН”-НИЙ ХҮРЭЭНД ЗЭЭЛ АВСАН ЗАРИМ ЗЭЭЛДЭГЧИД ЗЭЭЛИЙН ХӨРӨНГИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН ЭСЭХ НЬ НОТЛОГДОХГҮЙ, ТӨСӨЛД ЗААСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЖИГДРЭЭГҮЙ БАЙНА.

2.1. Холбогдох хуулийн дагуу хоршоо нь шинээр үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаа нь тайлагнагдаж байна уу?

2.1. Хоршоо шинээр үүсгэн байгуулахдаа хуульд заасан шаардлагын дагуу бүртгүүлж байгаа хэдий ч дийлэнх хоршооны тайлангаас үзэхэд үйл ажиллагаа явуулаагүй төлөвөөр санхүүгийн тайланг илгээсэн байна.

2.1.1 Хоршоог үүсгэн байгуулсан гэрээнд хоршооны зорилго, эрх, үүрэг, хариуцлагыг тусгасан уу?

Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд Баянхонгор аймгийн хэмжээнд нийт 389 хоршоо хамрагдсанаас 87 хоршоо нь 2003-2023 оны хооронд байгуулагдсан, харин 302 хоршоо нь 2024-2025 онд шинээр үүсгэн байгуулагдсан байна.

Тус хөдөлгөөнийг дэмжих зорилгоор “Хоршооны гишүүн малчны зээл”-ийг 2024 оноос эхлэн олгож эхэлсэн бөгөөд уг зээл нь хоршооны үйл ажиллагааг дэмжих, малчдын үйлдвэрлэл, орлогыг нэмэгдүүлэх, хоршооллын тогтолцоог бэхжүүлэх зорилготой.

Нэг зээлдэгчид олгох зээлийн дээд хэмжээ нь 50.0 сая төгрөг, 5 хүртэлх жилийн хугацаатайгаар олгосон бөгөөд жилийн хүү нь 18 хувиас хэтрэхгүй, үүнээс 12 хувийн хүүгийн хөнгөлөлтийг төрөөс санхүүжүүлэхээр зохицуулсан. Энэхүү зээл нь хоршооны гишүүн малчдад үйлдвэрлэл, үйлчилгээ, мал аж ахуйн үйл ажиллагаагаа өргөжүүлэх, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр ашиглаг зорилттой хэрэгжиж байна.

Аудитаар хамрагдсан нийт 389 хоршооны үүсгэн байгуулалтын баримт бичгийг шалгахад хоршооны зорилго, эрх үүргийг бүрэн тусгасан байгаа нь Хоршооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1¹ дэх заалтыг хангаж ажилласан байна.

2.1.2 Хоршооны дүрэмд хоршоог үүсгэн байгуулагчдын оруулах хувь хөрөнгийн хэмжээг тусган баталж, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн үү?

Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд малчны зээлд хамрагдсан нийт 389 хоршооны дүрэмд дүн шинжилгээ хийхэд хоршооны дүрэмд үүсгэн байгуулагчдын оруулах хувь хөрөнгийн хэмжээ, нөхцөл, бүтэц, хэлбэрийг хоршооны онцлог, дотоод зохион байгуулалтаас хамааран харилцан адилгүй байдлаар тодорхойлсон байна.Тухайлбал:

- “Дэвжих ембүү өсөх өгөөж” хоршоо нэг гишүүний оруулах хөрөнгийг 1 төлөг ба түүнээс дээш,
- “Хүрэн бэлчирийн авшиг” хоршоо 1 төлгөн хонь,
- “Хөх улаан хошууны хишиг буян” хоршоо гишүүний хөрөнгийг 11,250 төгрөг, харин даргын хөрөнгийг 90,000 төгрөг
- “Таван хошуу бүрэн” хоршоо нэг гишүүний нийлүүлэх хөрөнгийн хэмжээг 100-1,000,000 төгрөг хүртэл байхаар тусгасан.

Хоршооны дүрэмд гишүүдийн заавал байршуулах хөрөнгийн хэмжээг тусгахаас гадна үүнээс давхар сайн дурын үндсэн дээр нийлүүлэх хөрөнгийг нэмэлтээр тусгасан байгаа нь хоршооны хөрөнгийн бүтэц, үүсгэн байгуулагчдын хүлээх санхүүгийн үүрэг хариуцлагыг тодорхойлох зохицуулалт харилцан адилгүй хэрэгжихээр байна.

Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд Баянхонгор аймагт хамрагдсан нийт 389 хоршооноос 14 хоршооны үүсгэн байгуулалтын баримт бичиг, дүрэм болон улсын бүртгэлийн мэдээллийг тулган шалгахад улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгэгдсэн хоршооны нийт хөрөнгийн хэмжээ нь тухайн хоршоодын дүрэмд заасан нийт гишүүдийн заавал байршуулах хувь хөрөнгийн дүнгээс бага байна.

¹ Хоршоог үүсгэн байгуулагчид хоршоо үүсгэн байгуулах талаар гэрээ байгуулж, уг гэрээнд хоршооны зорилго, үүсгэн байгуулагчдын оруулах хувь хөрөнгийн хэмжээ, эрх, үүрэг, хариуцлага зэргийг тусгана

Улсын бүртгэлийн мэдээлэл болон хоршооны дүрэм хооронд хөрөнгийн зөрүүтэй байдал үүссэнээр хоршооны төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

2.1.3 Хоршооны тухай хууль болон хоршооны дүрэмд заасныг үндэслэн хоршооны хөгжлийн санд төвлөрүүлэх хөрөнгийг байршуулсан уу?

“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд зээл авсан хоршоод дүрэмд заасан хоршооны хөгжлийн санг байгуулаагүй байна.

Аудитаар Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкнуудаас зээл авсан хоршоодын нэрсийг хүргүүлж хоршоо хөгжлийн сан байгуулсан эсэхэд судалгаа гаргуулан авахад хоршоодын харилцах данснаас өөр тусгайлсан данс нээсэн талаарх мэдээлэл ирүүлээгүй байна.

Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж буй “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ний хүрээнд зээл авсан хоршоодын дансны лавлагаа, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээр ирүүлсэн тайлан мэдээнээс үзэхэд “БНЭ хоршоо”-ноос бусад нь дүрэмд заасан хоршооны хөгжлийн санг байгуулаагүй байна.

Хоршооны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Хоршооны хөгжил, хоршооны гишүүний нийгэм, эдийн засгийн байдлыг дээшлүүлэх, амьдралын чанар, амьдрах орчныг сайжруулах зорилгоор хоршоо хөгжлийн сантай байж болно” гэж заасан байна.

Иймд хоршоо байгуулах дүрэмд заасан хоршоо хөгжлийн сан байгуулах асуудалд нягтлан бодох бүртгэлээр хяналт тавьж ажиллах зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-д хүргүүлэв.

2.1.4 Хоршооны тухай хууль болон хоршооны дүрэмд заасныг үндэслэн болзошгүй эрсдэлээс хамгаалах санд заавал байлгах хөрөнгийг байршуулсан уу?

“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд зээл авсан хоршоод дүрэмд заасан болзошгүй эрсдэлээс хамгаалах санг байгуулаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж буй “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ний хүрээнд зээлд авсан хоршоодын дансны лавлагаа, аймгийн ЗДТГ-ын СТСХ-т харьяалагдаж тайлагнадаг 386 хоршооны тайлан мэдээнээс үзэхэд бүгд болзошгүй эрсдэлээс хамгаалах санг байгуулаагүй байна.

Дээрх зөрчил нь Хоршооны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1²-д заасан заалтыг хэрэгжүүлээгүй байна.

² 25.1.Хоршооны тухайн жилийн борлуулалтын нийт орлогын 20 хүртэл хувийг болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хуваарилна.

Болзошгүй эрсдэлээс хамгаалах санд заавал байлгах хөрөнгийг байршуулах хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь хяналт тавих механизм байхгүй, хариуцлага хүлээх хууль эрх зүйн заалт байхгүйтэй холбоотой байна.

Иймд хуулийн хэрэгжилтийг хангуулах тогтолцоо бүрдүүлж, хяналт хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг чиг үүрэг бүхий Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх саналыг УАГ-т уламжлахаар шийдвэрлэв.

2.1.5 Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан хоршоод нь холбогдох хууль, журам, зааварт заасны дагуу тайлан гаргаж, бүртгэл хөтөлж байна уу?

Баянхонгор аймгийн хэмжээнд 2024-2025 онд нийт 389 хоршооны нийт 389 хоршооны 2,185 гишүүнд “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд 64,268.9 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна.

Хуулийн хүрээнд хоршоо нь санхүүгийн үйл ажиллагаагаа бүрэн, үнэн зөв бүртгэж, холбогдох тайлан мэдээг хууль тогтоомжид заасан хугацаанд гарган тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлан ирүүлсэн 295 хоршооны тайлангийн мэдээллийг судалж үзэхэд 285 хоршоо нь 2025 онд үйл ажиллагаа явуулаагүй талаар тайлагнасан байна. Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулж, санхүүгийн тайлан ирүүлсэн 10 хоршоо нийт 7.8 сая төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөхөөр тайлагнажээ.

Аудитын илрүүлэлт:

2025 оны байдлаар хоршоодын 75.8 хувь буюу 295 хоршоо нь санхүүгийн тайлангаа хугацаанд нь гаргаж, тайлагнасан, 24.2 хувь буюу 94 хоршоо санхүүгийн тайланг гаргаагүй байна.

Энэ нь Хоршооны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д “Хоршооны хөрөнгө, эх үүсвэрийг энэ хуульд заасан журам, заавар, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгэнэ” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд олгосон зээлийн хөрөнгө нь хоршооны дансаар дамжин олгогдоогүй, харин хоршооны гишүүн малчидтай байгуулсан зээлийн гэрээний үндсэн дээр шууд малчны данс руу шилжүүлсэн ба ихэнх хоршоо үйл ажиллагаа явуулаагүй Х” тайлан гаргасан шалтгаан гэж үзэж байна.

Нийт санхүүгийн тайлан ирүүлээгүй хоршоодыг үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрийн байршлаар нь ангилбал Баянхонгор сум 16, Баян-Овоо сум 15, Эрдэнэцогт сум 10, Жинст сум 8, Галуут сум 7 буюу нийт тайлан ирүүлээгүй

хоршоодын 59.6 хувийг эзэлж байгаа нь хоршоодын үйл ажиллагаа, бүртгэл, тайлагналд тавих хяналт сул байгааг илтгэж байна.

Дээрх 94 хоршоонд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авах зөвлөмжийг Баянхонгор аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлэв.

2.2 Хоршооны малчдад олгосон хөнгөлөлттэй зээлийг шалгуур хангасан малчинд олгож, үр дүнг хянаж байна уу?

2.2. Хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр нь малчдын амьдралд чухал хувь нэмэр болсон хэдий байгаль уур амьсгалын нөхцөл байдал, хэрэгжих хугацаанаас шалтгаалж зээлийн үр ашгийг тодорхойлох боломжгүй байна.

2.2.1 Шалгуур хангасан хоршооны гишүүнд "Хоршооны гишүүн малчны зээл"-ийг олгосон уу?

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 166, 167 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам, Монгол банк, Зээлийн батлан даалтын сан болон арилжааны банкнууд харилцан тохиролцож, 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдөр “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээг байгуулсан байна.

Тус гэрээний зорилго нь уламжлалт мал аж ахуйн салбарыг уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллөөс хамгаалах, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, малчны хамтын санаачилга, хоршоог дэмжихэд оршино.

Ерөнхий гэрээний 3 дугаар хэсэгт хөнгөлөлттэй зээл хүсэгчийн хангасан байх 7 үндсэн шаардлагыг тусгасан ба эдгээр шаардлага нь зээлдэгчийн эрх зүйн байдал, хоршооны гишүүнчлэл, мал аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй эсэх, өмнөх зээлийн мэдээлэл, санхүүгийн сахилга бат болон бусад холбогдох нөхцөлүүдийг хамарсан байна.

Аудитаар ерөнхий гэрээнд заасан 7 шаардлагыг хангасан эсэхийг хоршооны зээл авсан 2,185 зээлдэгчийн хувийн хэрэгтэй танилцан шалгахад ерөнхий гэрээнд тусгасан шалгуурыг бүрэн хангасан байна.

2.2.2 Зээлийн эргэн төлөлт хуваарийн дагуу төлөгдөж байна уу?

“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд 2024-2025 онд 64,287.9 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан 2,185 зээлдэгч зээлээ хуваарийн дагуу бүрэн төлж, хугацаа хэтэрсэн зээл байхгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 166, 167 дугаар тогтоолд “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд олгох малчны зээлийн 6 нэгж хувийн хүүгээс давсан төлбөрийг төрөөс хариуцан төлөхөөр зохицуулсан. Үүний хүрээнд арилжааны банкнууд хөнгөлөлттэй зээл хүсэгч иргэнтэй байгуулсан зээлийн гэрээний эргэн төлөлтийн хуваарьт хөнгөлөлттэй зээл хүсэгчийн зээлийн хүүгийн төлбөр болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны зээлийн хүүгийн хөнгөлөлтийг тусгасан байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд 2024-2025 онд хөнгөлөлттэй зээл авсан 289 хоршооны 2,185 зээлдэгчид 64,268.9 сая төгрөгийн зээл олгосноос 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлбөл зохих 9,494.6 сая төгрөгөөс 10,412.5 сая төгрөгийг төлсөн буюу 917.9 сая төгрөгийн илүү төлөлттэй байна.

Хүснэгт №2 Баянхонгор аймгийн хэмжээнд олгосон зээлийн эргэн төлөлт-банкаар сая.төгрөг

№	Банк	Төлбөл зохих дүн	Төлсөн дүн	Зөрүү
1	Хаан банк	5,653.5	6,106.7	(453.2)
2	Төрийн банк	3,841.1	4,305.8	(464.7)
	Нийт	9,494.6	9,494.6	(917.9)

Эх сурвалж: Аудитын судалгааны дүн

Зээлдэгчид эргэн төлөлтийн хуваарьт заасан дүнгээс илүү болон дутуу төлөлт хийсэнтэй холбоотойгоор дараагийн төлбөл зохих төлбөрийн хуваарьт өөрчлөлт орж, төлөвлөгөөт болон бодит төлөлтийн дүнгийн хооронд зөрүү үүссэн байна. **Тухайлбал:** Баянхонгор аймгийн хэмжээнд ХААН банк болон Төрийн банкнаас зээл авсан нийт 2,185 зээлдэгчээс 290 нь зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлбөрөө бүрэн төлсөн байна. Харин 934 зээлдэгч нь гэрээнд заасан төлөлтийн хуваариас нийт 956.6 сая төгрөгөөр илүү төлөлт хийсэн бол 962 зээлдэгч нийт 38.7 сая төгрөгийн дутуу төлөлттэй байна.

Аудитын явцад зарим зээлдэгчтэй уулзаж, зээлийн эргэн төлөлтийн талаар тодруулахад ноолуурын зах зээлийн үнэ өсөж, орлого нэмэгдсэнтэй холбоотойгоор зээлийн үндсэн төлбөрийг хугацаанаас өмнө болон хуваарьт дүнгээс илүү хэмжээгээр төлсөн гэж тайлбарласан болно.

Хүснэгт №3 Баянхонгор аймгийн хэмжээнд олгосон зээлийн эргэн төлөлт-банкаар сая.төгрөг

Интервал	Хаан банк		Төрийн банк	
	тоо	дүн	тоо	дүн
Илүү төлөлт				
1<99,999	279	4.91	56	0.43
100,000-499,999	41	10.12	125	51.08
500,000-999,999	36	24.41	197	137.62
1,000,000<	89	446.76	111	281.22
Нийт	445	486.20	489	470.35
Хуваарийн дагуу төлсөн	265	-	24	-
Дутуу төлөлт				
1<99,999	791	17.53	91	1.61
100,000<499,999	68	9.97	5	1.10
500,000<999,999	2	1.45	2	1.82
1,000,000<	2	4.10	1	1.11
Нийт	863	33.04	99	5.64

Эх сурвалж: Аудитын судалгааны дүн

Зээлийн эргэн төлөлтийн банкнаас ирүүлсэн мэдээнд дүн шинжилгээ хийхэд зарим зээлдэгчид хугацаа хоцроож эргэн төлөлтөө хийсэн тохиолдол байгаа ч зээлийн ангилал хэвийн байна.

2.2.3 Монгол банкны орон нутаг дахь нэгж, Зээлийн батлан даалтын сан хяналтаа үр дүнтэй хэрэгжүүлсэн үү ?

Монгол банкны Баянхонгор аймаг дахь салбараас “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн хүрээнд Төрийн банк болон Хаан Банкаар дамжуулан олгосон зээлүүдэд хэсэгчилсэн болон иж бүрэн шалгалтыг хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

- 2024 оны 09 дүгээр сарын 11-ны өдөр Төрийн банкны олгосон 100 зээлдэгчийг хамруулан шалгалт хийхэд 15 зээлдэгчийн зээлийн хувийн хэрэгт,
- 2026 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Хаан банкны олгосон 16 зээлдэгчийг шалгахад 10 зээлийн хувийн хэрэгт тус тус зөрчил илэрч, шалгалтын хүрээнд холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.

Зээлийн батлан даалтын сангаас 2024 онд Баянхонгор аймгийн 16 сумын 194 хоршооны 1058 зээлдэгчид хяналт хийснээс 807 зээлдэгчийг зарцуулалтын баримтаар, 251 зээлдэгчийг газар дээр нь биечлэн шалгалтад хамруулсан байна.

Мөн 2025 онд 5 сумын 30 хоршооны 148 зээлдэгчид хяналт хийж, үүнээс 67 зээлдэгчийг зарцуулалтын баримтаар, 81 зээлдэгчийг газар дээр нь биечлэн шалгалтад хамруулжээ.

Монгол банкны түүвэр шалгалтаар зээлийн гэрээний нөхцөл, зориулалтын хэрэгжилт, барьцаа хөрөнгийн бүртгэл, зээлийн хувийн хэргийн бүрдүүлэлттэй холбоотойгоор зээлийн гэрээний заалт зөрчсөн, барьцааны гэрээг бүрэн

баталгаажуулаагүй, барьцаалсан хөрөнгийг улсын бүртгэлд бүртгүүлээгүй, зээлийн зориулалтын хяналтын баримт дутуу, зээлийн хувийн хэрэг бүрэн бүрдээгүй зэрэг зөрчлүүд илэрч зөрчлийг аргилгасан байна.

Гэсэн хэдий ч Монголбанк нь “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн хүрээний бүх зээлдэгчийг бүрэн хамруулан хяналт тавих боломж хязгаарлагдмал тул түүвэрчилсэн байдлаар шалгалт хийж байгаа нь илэрсэн зөрчлийн цар хүрээ, давтамжтай харьцуулахад хяналт шалгалтын хамрах хүрээ, үр нөлөөг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Аудитын илрүүлэлт:

“Хоршооны гишүүн малчны зээл”-д холбогдох байгууллагууд хяналт хэрэгжүүлж байгаа боловч зарим зээлдэгч түүвэрлэлтээс гадна орхигдож байгаагаас аудитаар зээлийн зориулалт, зарцуулалттай холбоотой зөрчил илэрсэн нь зээлийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Иймд төрийн байгууллагуудаас статистик тоо мэдээлэл авч дүн шинжилгээ хийн эрсдэлийг оновчтой тодорхойлон зээлийн зориулалтад тавих хяналтыг сайжруулах зөвлөмжийг Монгол банкны Баянхонгор аймаг дахь салбарт хүргүүлэв.

1.2.4 Хөнгөлөлттэй зээл авсан малчин нь зээлийг зориулалтын дагуу ашиглаж, үр дүнд хүрсэн үү?

Зээлийн зориулалт нь дараах төрлөөр олгогдсон бөгөөд үүнийг ангиллаар нь авч үзвэл:

Хүснэгт № 4. Зээлийн зориулалт

Зээлийн зориулалт	тоо	сая.төгрөг Дүн
Бүх төрлийн тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн үйлдвэрлэл, цех байгуулах, өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	40	1,173.0
Бэлчээрт худаг, уст цэг гаргах, усан хангамж байгуулах	42	1,494.0
Гахай, шувуу, зөгий, цаа буга зэрэг ашиг шимийг нь тогтмол хүртдэг тэжээвэр амьтны аж ахуй байгуулах, өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	7	200.0
Дотор мах боловсруулах үйлдвэр, цех байгуулах, өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	14	426.0
Мал аж ахуйн үйлдвэрлэлд зориулагдсан малчдын хөдөлмөрийг хөнгөөчилсөн техник, тоног төхөөрөмжийн дундын үйлчилгээ үзүүлэх, технологи нэвтрүүлэх	38	1,037.5
Мал бордох аж ахуй байгуулах, өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	142	4,315.6
Мал төхөөрөх цех, үйлдвэр байгуулах, өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	2	50.0
Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээ эрхлэх	59	1,482.9
Мал эмнэлгийн ажил, үйлчилгээ	2	100.0
Мал, малын гаралтай түүхий эдийн агуулах, зоорь, хөргүүр байгуулах	19	517.0
Мах, сүү, цагаан идээ бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэл, цех байгуулах, өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	117	3,760.6
Ноос, ноолуур, арьс шир бэлтгэх, анхан шатны тордолт хийх цэг, цех байгуулах, өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	8	305.0

Үржлийн мал худалдан бойжуулах, борлуулах	1321	38,746.8
ХАА-н гаралтай түүхий эдийг боловсруулах, үйлдвэрлэлийн зориулалттай барилга, байгууламж барих, өргөтгөх, засварлах, тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл, (автомашин), тоног төхөөрөмж худалдан авах	374	10,660.6
Нийт	2185	64,269.0

Эх сурвалж: Аудитын судалгааны дүн

Талбарын үе шатны ажлаар Эрдэнэцогт, Баян-Овоо, Өлзийт, Жинст, Баянговь, Баацагаан, Бууцагаан, Жаргалант, Галуут, Баянхонгор сумдын нийт 120 зээлдэгчийн төслийг газар дээр нь очиж түүвэрлэн шалгав.

Түүвэрлэн шалгасан ба дээрх зээлдэгчид малын тоо, ашиг шимийг өсгөх зорилгоор малын гаралтай түүхий эдийн гарцыг сайжруулах, малын хорогдол багасгах зорилгоор өвөлжөө хаваржааг өргөтгөх, арьс шир боловсруулах жижиг оврын тоног төхөөрөмж худалдан авах, худаг уст цэг гаргах, мах, махан бүтээгдэхүүнийг хадгалж эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх хөргүүрийн төхөөрөмж худалдан авах зэрэг үр дүнг гаргаж байна.

Гэвч талбар дээр ажиллах цаг хугацаанд Баянхонгор аймгийн нийт нутгаар гангийн байдалтай байгаагаас шалтгаалан отор нүүдэл хийж, малын түүхий эд, сүү цагаан идээ боловсруулах нөхцөл бүрдээгүй, үйл ажиллагаа явуулах бололцоогүй байдалтай байв.

Төсөл хэрэгжүүлэгч хоршооны төлөвлөсөн үр дүн бодит байдал дээр бололцооны түвшинд өргөжих бололцоотой зарим үйл ажиллагаанаас дурдвал:

- Баянговь сумын нэр бүхий хоршоо нь ингэний сүүг Баянхонгор аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан ингэний сүүний үйлдвэрт бүтээгдэхүүн нийлүүлэх зорилгоор хөдөөд сүү, саах тоног төхөөрөмжийг цахилгааны эх үүсвэрийн хамтаар шийдэж үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон.
- Шаргалжуут тосгонд хоршиж сүү цагаан идээ, чипс хэлбэртэй ааруул хийх тоног төхөөрөмж болон цагаан сарын үеэр их бага тавгийн идээний ааруул бусад бүтээгдэхүүн гаргах, тоног төхөөрөмж бэлтгэсэн.
- Галуут сумын хоршоо нь сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийн зориулалтаар газар авч мах нөөцлөх хөргүүрийн агуулах бэлтгэсэн.
- Бууцагаан сумд зээлийн хөрөнгөөр тариалангийн зориулалтай талбай шинээр хашиж тариалангийн ургамал тариалсан.

Дээрх байдлаас үзэхэд малчид зээлийг авч хамтарч хоршиж үйл ажиллагаа явуулж байгаа нь үр дүнд хүрэх бололцоотой байна.

Харин зарим зээлдэгчид зээлийн хөрөнгөөр тоног төхөөрөмж захиалсан, ирж байгаа гэх тайлбар өгч байгаа боловч нотлох боломжгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Мал худалдан авснаас бусад зориулалтаар зээл авсан 722 зээлдэгчээс санамсаргүй түүврийн аргаар 120 зээлдэгчийн сонгож, газар дээр нь үзэхэд 270.0 сая төгрөгийн зээл авсан 8 зээлдэгч зээлийн хөрөнгөө зориулалтын дагуу зарцуулсан эсэх нь тодорхойгүй байна.

Иймд зориулалтын дагуу зарцуулсан эсэхэд дахин хяналт хийж биелэлт ирүүлэх албан шаардлагыг Монгол банкны Баянхонгор дахь салбарт хүргүүлэв.

Мөн Үржлийн мал худалдан бойжуулах, борлуулах, мал бордох аж ахуй байгуулах, өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх 1463 зээлдэгчийг түүвэрлэн аймгийн Статистикийн хэлтсээс малын 3 жилийн тооллогын болон нэмэгдсэн хасагдсан мэдээллийг авч, малын тоо татан авч дүн шинжилгээ хийв.

Мал худалдан авч буй иргэд хооронд байгуулсан худалдах, худалдан авах гэрээг үндэслэн худалдагч талын дансанд бэлэн бусаар шилжүүлж, зээлийн зарцуулалтад хяналт тавьсан.

Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 8,191.1 сая төгрөгийн зээл авсан 269 малчны Статистикийн мэдээллийн санд байгаа А дансны бүртгэлийн худалдан авсан ангилалд тоо мэдээ хоосон байгаагаас үзэхэд хөнгөлөлттэй зээлийн ашиглалт, үр дүнг тооцох боломжгүй байна.

Иймд Засгийн газраас хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй зээлээр худалдан авч, борлуулсан малын тоо, тооллогын дүн мэдээг үнэн зөв оруулах талаар малчид болон мал тоологч нарт арга зүйн зөвлөгөө, сургалтыг мэргэжлийн байгууллагаар өгөх ажлыг зохион байгуулах зөвлөмжийг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэв.

Жилийн эцсийн мал тооллогод Статистикийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3-т заасны дагуу Шинэ хоршоо чинээлэг малчин арга хэмжээнд хамрагдсан малын тоон мэдээлэл хөдөлгөөн өөрчлөлтийг тусгаж ажиллах зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт хүргүүлэв.

Аудитаар нийт 8,461.1 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 270.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага өгч, 8,191.1 сая төгрөгийн 4 зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтнуудад хүргүүлж, хуульд заасан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэх, хяналтын тогтолцоог бүрдүүлэх зөвлөмжийг холбогдох газарт хүргүүлэх 1 саналыг ҮАГ-т уламжлав.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Орон нутгийн түвшинд “Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай” арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг тодорхойлоогүй, санхүүжилтийн дүнг бүрэн төлөвлөөгүйгээс үр дүнг тооцоогүй байна.
2. Хоршоо шинээр үүсгэн байгуулахдаа хуульд заасан шаардлагын дагуу бүртгүүлж байгаа хэдий ч дийлэн хоршооны тайлангаас үзэхэд үйл ажиллагаа явуулаагүй төлөвөөр тайлан илгээсэн байна.
3. Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж буй “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ний хүрээнд зээлд авсан хоршоод болзошгүй эрсдэлээс хамгаалах санг байгуулаагүй байна.
4. Хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр нь малчдын амьдралд чухал хувь нэмэр болсон хэдий байгаль уур амьсгалын нөхцөл байдал, хэрэгжих хугацаанаас шалтгаалж зээлийн үр ашгийг тодорхойлох боломжгүй байна.
5. Хөнгөлөлттэй зээл авсан малчдад Монгол банк, Зээлийн батлан даалтын сан хяналт хэрэгжүүлж байгаа ч зээлийн хөрөнгийг төсөлд заасан зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчил илэрсэн байна.

-oOo-

ЗӨВЛӨМЖ:

НЭГ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Э.ЭНХБАТ ТАНАА:

1. “Шинэ хоршоо- чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тодорхой тусгаж, үр дүнг тооцож, ард иргэдэд нээлттэй тайлагнаж ажиллах.
2. Статистикийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3-т заасны дагуу Шинэ хоршоо чинээлэг малчин арга хэмжээнд хамрагдсан малын тоон мэдээлэл хөдөлгөөний тооллогын дүнд тусгахад тоолох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд үүрэг чиглэл өгч ажиллах.

ХОЁР. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗДТГ-ЫН СТСХ-ИЙН ДАРГА С.БАЙГАЛМАА ТАНАА:

3. Баянхонгор аймгийн хэмжээнд хоршооны хэлбэрээр үйл ажиллагаа явуулж буй хоршоодын санхүүгийн тайланд дүрэмд заасны дагуу эрсдэлээс хамгаалах сан, хоршоо хөгжлийн сан зэрэг мэдээллийг үнэн зөв тусгуулахад хяналт тавих
4. Хоршооны хэлбэрээр үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдүүдийн санхүүгийн тайланг хугацаанд нь хүлээн авах талаар анхаарч ажиллах.

ГУРАВ. МОНГОЛ БАНКНЫ ЗАХИРАЛ Г.ОЛОНБАЯР ТАНАА:

5. Төрийн байгууллагуудаас статистик тоо мэдээлэл авч дүн шинжилгээ хийн эрсдэлийг оновчтой тодорхойлон, зээлийн зориулалтад тавих хяналтыг сайжруулан ажиллах.

ДӨРӨВ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА Т.ЭРДЭНЭБАТ ТАНАА:

6. Засгийн газраас хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй зээлээр худалдан авч, борлуулсан малын тоо, тооллогын дүн мэдээг үнэн зөв оруулах талаар малчид болон мал тоологч нарт арга зүйн зөвлөгөө, сургалтыг мэргэжлийн байгууллагаар зохион байгуулж, зээлийн ашиглалтад тавих хяналтыг сайжруулах.

-oOo-

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:

1. Хоршооны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1³-д заасан заалтыг хэрэгжүүлэх хяналтын тогтолцоо бүрдүүлэх зөвлөмжийг холбогдох газарт хүргүүлэх саналыг уламжилж байна.

-oOo-

³ 25.1.Хоршооны тухайн жилийн борлуулалтын нийт орлогын 20 хүртэл хувийг болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хуваарилна.